**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/162/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024.02.24 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 13
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 17
4.1 Ерөнхий зүйл ..... 17
4.2 Материаллаг байдал ..... 17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 19
5.1 Төлбөрийн акт ..... 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 20


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.19 № 2/08

танай____________-ны № ____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ОЮУНБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Ажилчдад олгосон цалингийн урьдчилгаанаас 300.0 мянган төгрөгийг суутгаагүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, мөн толилуулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтрээгүй.

5020309

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **43488583.00** | **72523821.00** |
| **33** | **АВЛАГА** | 3309683.00 | 3319421.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 9738.00 |
| **335** | **Бусад авлага** | 3309683.00 | 3309683.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 3309683.00 | 3309683.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 40178900.00 | 69204400.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 40178900.00 | 69204400.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 550000.00 | 1681600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19169100.00 | 27166600.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 0.00 | 405000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 0.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 623200.00 | 825000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 19836600.00 | 39126200.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6906462119.08** | **7896053479.67** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 6906462119.08 | 7896053479.67 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5459184119.08 | 6449075479.67 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5086448096.49 | 6165510935.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -563364996.36 | -720758767.24 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 67200000.00 | 67200000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18386666.75 | -30706666.79 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 68227616.82 | 107359316.82 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -39822435.31 | -48329128.02 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 103507187.00 | 162211487.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -54734682.81 | -63521697.59 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 140000.00 | 140000.00 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 809970000.00 | 809970000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1447278000.00 | 1446978000.00 |
| 39301 | Программ хангамж | 2160000.00 | 2160000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -960000.00 | -1260000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1446078000.00 | 1446078000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6949950702.08** | **7968577300.67** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **150000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 150000.00 |
| **413** | **Өглөг** | 0.00 | 150000.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 150000.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6949950702.08** | **7968427300.67** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6949950702.08 | 7968427300.67 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1901310973.58 | 1901310973.58 |
| 51101 | Өмч:  - төрийн | 1901310973.58 | 1901310973.58 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3769063989.13 | 4787540587.72 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3876630088.37 | 3769063989.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -107566099.24 | 1018476598.59 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1279575739.37 | 1279575739.37 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6949950702.08** | **7968577300.67** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1082800036.20** | **3839667540.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **39312000.00** | **1113464839.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 39312000.00 | 1113464839.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 39312000.00 | 1113464839.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 39312000.00 | 1113464839.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1043488036.20** | **2726202701.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 366850400.00 | 813654300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 366850400.00 | 813654300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 86178801.00 | 505965301.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 53966000.00 | 28730000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 429720000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 32212801.00 | 47515301.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 590458835.20 | 1406583100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 590458835.20 | 1406583100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1182866135.33** | **2821190941.41** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1182866135.33** | **2821190941.41** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1163082162.10 | 2736514357.70 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 275876404.02 | 675570147.73 |
| 210101 | Үндсэн цалин | 144148522.88 | 294820609.47 |
| 210102 | Нэмэгдэл | 18348895.23 | 55034646.55 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12326989.00 | 49464890.74 |
| 210104 | Урамшуулал | 7576213.44 | 67509390.30 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 93475783.47 | 208740610.67 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34472654.20 | 83158837.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24622859.27 | 56691767.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2540898.47 | 6670729.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2139245.04 | 5292604.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 472914.47 | 1318493.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4696736.95 | 13185241.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 442265507.33 | 1143512658.62 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7363821.67 | 33875818.14 |
| 210302 | Түлш, халаалт | 428576672.66 | 1085936060.48 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6325013.00 | 23700780.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31381194.42 | 35202554.66 |
| 210401 | Бичиг хэрэг | 2660750.00 | 4535500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3806980.00 | 5694200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2112897.42 | 5281527.66 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 495000.00 | 100000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21317017.00 | 19591327.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 988550.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 27406357.00 | 14033800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 250000.00 |
| 210602 | Тавилга | 0.00 | 428000.00 |
| 210604 | Урсгал засвар | 27406357.00 | 13355800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1862000.00 | 2482000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1862000.00 | 2482000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 60073106.00 | 49689011.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 54594260.00 | 44551300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 290000.00 | 238500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 109846.00 | 109846.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44000.00 | 66000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500000.00 | 500000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 4035000.00 | 4223365.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 289744939.13 | 732865348.41 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 117510823.99 | 545557870.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 172234115.14 | 187307478.41 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 19783973.23 | 84676583.71 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500000.00 | 2800000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500000.00 | 2800000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 19283973.23 | 66889181.36 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19283973.23 | 66889181.36 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 14987402.35 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 14987402.35 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-100066099.13** | **1018476598.59** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 7500000.10 | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 7500000.10 | 0.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -7500000.10 | 0.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-107566099.24** | **1018476598.59** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1043488036.20** | **2726202701.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1043488036.20** | **2726202701.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 366850400.00 | 813654300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 366850400.00 | 813654300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 86178801.00 | 505965301.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 53966000.00 | 28730000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 429720000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 32212801.00 | 47515301.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 590458835.20 | 1406583100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 590458835.20 | 1406583100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1043488036.20** | **2662366701.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1043488036.20** | **2662366701.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1023704062.97** | **2577690117.29** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 279154911.46 | 675420147.73 |
| 210101 | Үндсэн цалин | 143116789.12 | 294820609.47 |
| 210102 | Нэмэгдэл | 20021407.23 | 55034646.55 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12239993.80 | 49464890.74 |
| 210104 | Урамшуулал | 7469879.10 | 67359390.30 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 96306842.21 | 208740610.67 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34503829.76 | 83168575.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24098512.32 | 56701505.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2817093.00 | 6670729.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2209994.48 | 5292604.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 488929.59 | 1318493.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4889300.37 | 13185241.84 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 442265507.33 | 1143512658.62 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7363821.67 | 33875818.14 |
| 210302 | Түлш, халаалт | 428576672.66 | 1085936060.48 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6325013.00 | 23700780.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10815147.42 | 11578698.66 |
| 210401 | Бичиг хэрэг | 2071950.00 | 1343600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500000.00 | 3054200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2112897.42 | 5281527.66 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 545000.00 | 100000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5585300.00 | 1799371.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 40000000.00 | 40753420.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 19850000.00 |
| 210602 | Тавилга | 0.00 | 428000.00 |
| 210604 | Урсгал засвар | 40000000.00 | 20475420.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1862000.00 | 2482000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1862000.00 | 2482000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 84231563.00 | 82855911.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 78752717.00 | 77718200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 290000.00 | 238500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 109846.00 | 109846.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44000.00 | 66000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500000.00 | 500000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 4035000.00 | 4223365.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 130871104.00 | 537918706.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 130745104.00 | 537918706.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 126000.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19783973.23** | **84676583.71** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500000.00 | 2800000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500000.00 | 2800000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 19283973.23 | 66889181.36 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19283973.23 | 66889181.36 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 14987402.35 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 14987402.35 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **0.00** | **63836000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **0.00** | **63836000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **63836000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0.00 | 63836000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 63836000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **0.00** | **-63836000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **20221 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,901,310,973.58 | 1,279,575,739.37 | 3,876,630,088.37 | 0.00 | 7,057,516,801.32 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,901,310,973.58** | **1,279,575,739.37** | **3,876,630,088.37** | **0.00** | 7,057,516,801.32 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -107,566,099.24 | 0.00 | -107,566,099.24 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,901,310,973.58** | **1,279,575,739.37** | **3,769,063,989.13** | **0.00** | 6,949,950,702.08 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,901,310,973.58** | **1,279,575,739.37** | **3,769,063,989.13** | **0.00** | 6,949,950,702.08 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,901,310,973.58** | **1,279,575,739.37** | **3,769,063,989.13** | **0.00** | 6,949,950,702.08 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 1,018,476,598.59 | 0.00 | 1,018,476,598.59 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,901,310,973.58** | **1,279,575,739.37** | **4,787,540,587.72** | **0.00** | 7,968,427,300.67 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хэтрэлт, хэмнэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2220237400.00 | 2139208161.29 | 81029238.71 | 96.35 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2220237400.00 | 2139208161.29 | 81029238.71 | 96.35 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2217437400.00 | 2136408161.29 | 81029238.71 | 96.35 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 744068800.00 | 675420147.73 | 68648652.27 | 90.77 |
| 210101 | Үндсэн цалин | 361873400.00 | 294820609.47 | 67052790.53 | 81.47 |
| 210102 | Нэмэгдэл | 76309000.00 | 55034646.55 | 21274353.45 | 72.12 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 57228000.00 | 49464890.74 | 7763109.26 | 86.43 |
| 210104 | Урамшуулал | 36153400.00 | 67359390.30 | -31205990.30 | 186.32 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 212505000.00 | 208740610.67 | 3764389.33 | 98.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 93008500.00 | 83168575.28 | 9839924.72 | 89.42 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63245800.00 | 56701505.77 | 6544294.23 | 89.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7440700.00 | 6670729.99 | 769970.01 | 89.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5952500.00 | 5292604.03 | 659895.97 | 88.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1488100.00 | 1318493.65 | 169606.35 | 88.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14881400.00 | 13185241.84 | 1696158.16 | 88.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1143515000.00 | 1143512658.62 | 2341.38 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 32945000.00 | 33875818.14 | -930818.14 | 102.83 |
| 210302 | Түлш, халаалт | 1086870000.00 | 1085936060.48 | 933939.52 | 99.91 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23700000.00 | 23700780.00 | -780.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12036000.00 | 11578698.66 | 457301.34 | 96.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 1200000.00 | 1343600.00 | -143600.00 | 111.97 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2500000.00 | 3054200.00 | -554200.00 | 122.17 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5236000.00 | 5281527.66 | -45527.66 | 100.87 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 600000.00 | 100000.00 | 500000.00 | 16.67 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2500000.00 | 1799371.00 | 700629.00 | 71.97 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 89800000.00 | 89799720.00 | 280.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 45800000.00 | 45799900.00 | 100.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 24000000.00 | 23999820.00 | 180.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2500000.00 | 2482000.00 | 18000.00 | 99.28 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2500000.00 | 2482000.00 | 18000.00 | 99.28 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9359000.00 | 7619311.00 | 1739689.00 | 81.41 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2500000.00 | 2481600.00 | 18400.00 | 99.26 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500000.00 | 0.00 | 500000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300000.00 | 238500.00 | 61500.00 | 79.50 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 113000.00 | 109846.00 | 3154.00 | 97.21 |
| 210807 | Газрын төлбөр | 5380000.00 | 4223365.00 | 1156635.00 | 78.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 123150100.00 | 122827050.00 | 323050.00 | 99.74 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 123150100.00 | 122827050.00 | 323050.00 | 99.74 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | **2220237400.00** | **2139208161.29** | **81029238.71** | **96.35** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 813654300 | 747612463.64 | 66041836.36 | 91.9 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 813654300 | 747612463.64 | 66041836.36 | 91.9 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1406583100.00 | 1391595697.65 | 14987402.35 | 98.9 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1406583100.00 | 1391595697.65 | 14987402.35 | 98.9 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **85,422,157.00** | **505,117,956.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **85,422,157.00** | **505,117,956.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 85,422,157.00 | 505,117,956.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 77,222,217.00 | 90,026,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 77,222,217.00 | 90,026,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,199,940.00 | 415,091,656.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,199,940.00 | 415,091,656.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **756,644.00** | **847,345.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 756,644.00 | 847,345.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 86,178,801.00 | 505,965,301.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 86,178,801.00 | 505,965,301.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 53,966,000.00 | 28,730,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 429,720,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 32,212,801.00 | 47,515,301.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 0.00 | 0.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар нь орон нутагт биеийн тамир спортын жигд хөгжүүлэх, нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх,хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, сургалт дасгалжуулалтын орчин үеийн шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх үйл ажиллагаа явуулдаг байна.

Тайлант онд “Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортыг хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.хамтран ажиллах” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын  2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Биеийн тамир спортын газрын даргын 2021 оны А/170 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлд ашиглаж санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор Биеийн тамир спортын газрын  2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,896,053.5 мянган төгрөг буюу 14.7 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 43,488.6 | 72,523.8 | 29,035.2 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 3,309.7 | 3,319.4 | 9.7 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 40,178.9 | 69,204.4 | 29,025.5 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 6,906,462.1 | 7,896,053.5 | 989,591.4 |
| Үндсэн хөрөнгө | 7,583,730.9 | 8,760,629.7 | 1,176,898.8 |
| Хуримтлагдсан элэгдэл | (677,268.8) | (864,576.3) | (187,307.5) |
| **Нийт хөрөнгө** | 6,949,950.7 | 7,968,577.3 | 1,018,626.6 |
| Өр төлбөр | (0.0) | 150.0 | 150.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 6,949,950.7 | 7,968,427.3 | 1,018,476.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 6,949,950.7 | 7,968,577.3 | 1,018,626.6 |

Авлагын дансны үлдэгдэл 3,319.4 мянган төгрөг байгаа нь Тус байгууллагын даргын тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд Шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 3309.7 мянган төгрөгийг БТСГ-ын төсвөөс олгосон нь голлох дүнг эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,204.4 мянган төгрөг болж 29,025.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн худалдан авалтаар 264,836.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, үнэ төлбөргүй 402.0 мянган төгрөгийн бараа материал авч нийт 268,743.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, бэлэн бүтээгдэхүүн данснаас 235,810.8 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,760,629.7 мянган төгрөг болж 1,176,898.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 63,836.0 мянга, Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.02.13-ны өдрийн 13/11 тоот тогтоолоор Оготнотой булгийн хөл бөмбөгийн талбайг 85,020.0 мянга, 7-р багийн төв, спорт залны барилга 581,659.5 мянга, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн тохижилт гүйлтийн замыг 148,274.4 мянга, зүлэгжүүлэлтийг 164,109.8 мянга, Дөвөнтийн залны гадна засварыг 30,000.0 мянга, тугийн суурь 4,000.0 мянга, Дөвөнтийн заалны их засварыг тус тус эзэмшүүлсэнтэй холбоотой байна. Тайлант онд үндсэн хөрөнгө данснаас хасаагүй байна.

Цалингийн суутгал хийдээ Шүүхийн шийдвэрийн суутгалыг давхар суутгаж өглөг үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,968,427.3 мянган төгрөг болж 1,018,626.6 мянган төгрөгөөр өссөн нь үеийн үр дүнгээр хуримтлагдсан 1,018,626.6 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,925,329.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,925,329.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 40,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,965,323.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 2,220,237.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,139,208.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,139,208.2 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь Цалин хөлс 68,648.7 мянга, Ажил олгогчоос олгох ЭМНДШ 9,839.9 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс 1,739.7 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна. Цалингийн зардал хэмнэсэн шалтгаан нь 3 дасгалжуулагч дутуу ажилласантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/ төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 688,004,200.00 | 621,985,413.64 | 66,018,786.36 | 90.4 |
| 2 | 80305 Биеийн тамирын уралдаан тэмцээн | 80,174,500.00 | 80,161,350.00 | 13,150.00 | 100.0 |
| 3 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 2,800,000.00 | 2,800,000.00 | 0.00 | 100.0 |
| 4 | 82106 Нийтийн биеийн тамир | 42,675,600.00 | 42,665,700.00 | 9,900.00 | 100.0 |
| 5 | 80112- Нийтлэг үйлчилгээ | 1,406,583,100.00 | 1,391,595,697.65 | 14,987,402.35 | 98.9 |
| | НИЙТ | 2,220,237,400.00 | 2,139,208,161.29 | 81,029,238.71 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Биеийн тамир спортын улсын хорооны даргын 2022 оны 10-р сарын 27 өдрийн А/209 тушаалаар “Монголын хүүхдийн спортын зуны VII наадмыг 2023 онд зохион байгуулах эрх олгох тухай” шийдвэрийн дагуу 419,9 сая төгрөг, Аймгийн засаг даргын А/201 тоот захирамжаар Эрүүл мэндийн төлөө “Цаг гаргая аяны” хүрээнд 5,5 сая төгрөг, мөн 2023 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн А/150 дугаар захирамжаар 4,3 сая төгрөг, мөн 2023 оны А/75 дугаар захирамжаар волейболын клубуудын аварга шалгаруулах тэмцээнд 28,7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 47,5 сая төгрөг төвлөрснийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллагад худалдан авалтын төлөвлөгөө байхгүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулах урсгал зардал байхгүй байхгүй байна.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 1,086,870.0 мянга, гэрэл цахилгааны зардалд 32,945.0 мянга, цэвэр бохир усны зардалд 32,700.0 мянган төгрөг батлагдсанаас “Баялаг дулаан” ХХК, “Зүүн шанд” ХХК, “Рашаант хайрхан” ХХК, “ФЮМ” ХХК, “Хөвших Од” ХХК, “Чандмань-Баянхонгор” ХК, “Эх бүрдэн” ХХК-иудтай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК,-тай цахилгаанаар хангах гэрээ, “Чандмань-Баянхонгор”ХК-тай цэвэр, бохир усаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 813,654.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,136.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,695.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж аудитаар 380.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 19,786.2 мянган төгрөгийн 4 албан шаардлага, нийцлийн аудиттай холбоотой 1 зөвлөж өгснийг биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 221 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 380.0 | 1 | 380.0 | 100% |
| Албан шаардлага | 4 | 19,786.2 | 3 | 16,476.5 | 83.3% |
| Зөвлөмж | 1 | - | 1 | - | 100% |
| **Нийт дүн** | **1** | **20,166.3** | **1** | **16,856.5** | **94.3%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Ажилчдад олгосон цалингийн урьдчилгаанаас 300.0 мянган төгрөгийг суутгаагүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т заасан “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

_Шийдвэрлэсэн нь_: Авлагаар тусгаагүй цалингийн урьдчилгаа 300.0 мянган төгрөгийг холбогдох албан хаагчаас суутган тооцож төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов. .

### 5.2 Албан шаардлага

5.2.1. Чөлөөт бөхийн U15,U17, U20 насны УАШТ тэмцээний зардалд 2023.03.02-ны өдөр 6,630.0 мянган төгрөгийг дараа тайлангаар авсан боловч анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: Дараа тайлангаар авсан 6,630.0 мянган төгрөгийн анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Сагсан бөмбөг U16 насны УАШТ тэмцээний зардалд 2023.04.24-ний өдөр 6,000.0 мянган төгрөгийг дараа тайлангаар авсан боловч анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13.4-т заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: Дараа тайлангаар авсан 6,000.0 мянган төгрөгийн анхан шатны баримтыг нөхөн бүрдүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3. Спорт, цогцолбор усан бассейны барилгын “RMB”ХХК 8,730,550.1 мянган төгрөгөөр гэрээ байгуулан 2023 онд ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж эхэлсэн байхад үндсэн хөрөнгийн дансанд дуусаагүй барилга байгууламжийн дансанд 809,970.0 мянган төгрөгөөр бүртгэж, шийдвэр гараагүй гэсэн шалтгаанаар барилгыг хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Спорт, цогцолбор усан бассейны барилгын 8,730,550.1 мянган төгрөгийн хөрөнгийн шийдвэр гаргуулах хүсэлтийг тавьж, нягтлан бодох бүртгэлд тусгах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | | |
| Дүн | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажилчдад олгосон цалингийн урьдчилгаанаас 300.0 мянган төгрөгийг суутгаагүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. | 1 | 300.0 | 1 | 300.0 | | | | |
| Чөлөөт бөхийн U15,U17, U20 насны УАШТ тэмцээний зардалд 2023.03.02-ны өдөр 6,630.0 мянган төгрөгийг дараа тайлангаар авсан болович холбогдох баримтыг бүрдүүлээгүй байна. | 1 | 6,630.0 | | | 1 | 6,630.0 | | |
| Сагсан бөмбөг U16 насны УАШТ тэмцээний зардалд 2023.04.24-ний өдөр 6,000.0 мянган төгрөгийг дараа тайлангаар авсан болович анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байна. | 1 | 6,000.0 | | | 1 | 6,000.0 | | |
| Спорт, цогцолбор усан бассейны барилгын “RMB”ХХК 8,730,550.1 мянган төгрөгөөр гэрээ байгуулан 2023 онд ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж эхэлсэн байхад үндсэн хөрөнгийн дансанд дуусаагүй барилга байгууламжийн дансанд 809,970.0 мянган төгрөгөөр бүртгэж, шийдвэр гараагүй гэсэн шалтгаанаар барилгыг хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна | 1 | 8,730,550.1 | | | 1 | 8,730,550.1 | | |
| **Нийт дүн** | **4** | **8,743,480.1** | **1** | **300.0** | **3** | **8,743,180.1** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байхгүй | | | | | | | | |
| Дүн | **0** | **0** | | | | | | |

------------oOo-------------